

Япон улсад оршин суух гадаадын иргэдэд

Таны 12 орон бүхий Нийгмийн даатгал болон Татварын дугаарыг (Хувийн дугаар эсвэл “Миний дугаар” гэж нэрлэдэг) 2015 оны 10-р сарын эхэнд мэдэгдэх болно.

1. Хувийн дугаар (“Миний дугаар” гэж нэрлэдэг) гэж юу вэ?

Хувийн дугаарыг Нийгмийн даатгал болон Татварын дугаарын системийн дор олгодог бөгөөд энэ нь тухайн хүний хувийн мэдээллийг олон агентлагаас цуглуулан нэг дороос авах үндэс суурь нь болдог. Энэ систем нь Нийгмийн даатгал болон татварын системийн үр ашиг, ил тод байдлыг сайжруулж, олон нийтийг ая тухтай байлгаж, шударга нийгмийг бүтээдэг нийгмийн дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг.

Япон улсад оршин суугаа гадаадын иргэд (дунд-хугацааны оршин суугч, байнгын оршин суугч гэх мэт) мөн хувийн дугаартай байх болно.

2. Хувийн дугаарыг ямар тохиолдолд ашиглах вэ?

- ◆ Таны ажил олгогч татвар, нийгмийн даатгал төлөхөд шаардлагатай орлогын болон татварын суутгалын гэрчилгээ зэргийг үүсгэхэд хувийн дугаараа ашиглана.
- ◆ Татварын баримт бичгийг нотариатаар батлуулахын тулд даатгалын компаниуд таны Хувийн дугаарыг шаардана.
- ◆ Та ажилтны тэтгэвэр, тэтгэмжээ авахдаа тэтгэврийн албанд Хувийн дугаараа өгнө.
- ◆ Та халамжийн тэтгэмж авахдаа тухайн орон нутгийн захиргаанд хувийн дугаараа өгнө.

3. Шаардагдах үе шат

- ◆ Таны бүртгүүлсэн хаяг руу орон нутгийн захиргаанаас мэдэгдлийн хуудас илгээх болно.
Хэрэв та одоогийн оршин сууж байгаа хаягаа бүртгүүлээгүй тохиолдолд мэдэгдлийн хуудас авах боломжгүй тул оршин сууж байгаа хаягаа заавал баталгаажуулаарай.
- ◆ 2015 оны 10-р сараас эхлэн бүх айл өрхд дугтуйтай илгээмж очих бөгөөд энэ нь гэр бүлийн гишүүдийн хувийн дугаар бүхий мэдэгдлийн карт байх болно. Энэ карт нь нийгмийн даатгал, татвартай холбоотой хувийн дугаарыг агуулдаг учир маш чухал. Тиймээс та санамсаргүй тохиолдлоор хаяж гээгдүүлэхгүй байх тал дээр анхаараарай.
- ◆ Та хувийн дугаар бүхий карт захиалах боломжтой.
Захиалах хэд хэдэн хувилбар байгаа бөгөөд жишээлбэл та өөрийн цээж зургаа, анкетын хамтаар энэ имэйлд хавсарган илгээх боломжтой, эсвэл цээж зургаа ашиглан ухаалаг утсаар онлайнгаар хүсэлт гаргаж болно. Анкет бөглөх үйл явцын талаарх дэлгэрэнгүй зааврыг 2015 оны 10-р сард илгээх дугтуйнд хавсарган явуулах болно.
- ◆ Ингэснээр та хувийн дугаарын картыг авах болно.
Таны хувийн дугаарын карт бэлэн болсон мэдэгдлийг 2016 оны 1-р сар болон түүнээс хойшоо хугацаанд илгээх болно.
Хэрэв та картаа орон нутгийн захиргаанаас авахыг хүсвэл дараах 3 зүйлийг биедээ авчраарай. Картыг эхний удаа олгоход төлбөргүй болно.
 - ✓ Мэдэгдлийн карт
 - ✓ Карт хүсэх мэдэгдэл (анкет илгээсний дараа ирсэн)
 - ✓ Хувийн бичиг баримт (жолооны үнэмлэх, паспорт, оршин суух үнэмлэх гэх мэт)

4. Хувийн дугаарын карт гэж юу вэ?

- ◆ Энэхүү карт нь таны хувийн дугаартай холбоотой бүхий л үйл ажиллагаанд хувийн дугаар болон иргэний үнэмлэхийг баталгаажуулсан баримт бичиг юм.
- ◆ Мөн та үнэ, төлбөргүйгээр картаңдаа цахим сертификат суулган, татварын буцаалтыг онлайнаар авах боломжтой.
- ◆ Та картаа орон нутгийн засгийн газраас өөрийн эрхийн хүрээнд үзүүлдэг олон нийтийн номын сан, тамга, тэмдэгийн бүртгэл зэрэг үйлчилгээг авахад хэрэглэх боломжтой. Зарим орон нутагт олон нийтийн сертификатыг дэлгүүрээр дамжуулан олгодог.
- ◆ Таны оршин суугаа бүртгэлийн үндсэн карт хугацаа нь дуусах хүртэл хүчинтэй хэвээр байна. Гэхдээ та хувийн дугаар бүхий картаа авахдаа үүнийг хүлээлгэн өгөх шаардлагатай.
- ◆ Таны хувийн дугаарын картын чип-д таны нэр, хаяг, төрсөн он сар өдөр, хүйс, Хувийн дугаар, картын нүүрэн дээр бичигдсэн бусад мэдээлэл болон цахим сертификатын мэдээлэл багтах болно. Таны орлогын мэдээлэл гэх мэт хувийн, нууцлалтай мэдээллийг энд бүртгэхгүй.

5. Хувийн дугаарыг хэрэглэхэд анхаарах зүйл

- ◆ Ямар ч этгээд хуулиар зөвшөөрөөгүй тохиолдолд таны хувийн дугаарыг хураах болон ашиглахыг хориглоно. Тиймээс та бусдад хувийн дугаараа хайхрамжгүйгээр харуулахгүй байхыг анхаарна уу.
- ◆ Бусдын хувийн дугаарыг хууль бусаар эзэмшсэн, эсвэл эрх бүхий этгээд бусдын хувийн дугаар болон бусад нууц мэдээллийг гуравдагч талд олгосон тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6. Холбоо барих хаяг

- ◆ Дуудлага хүлээн авах
0570-20-0178 (Япон)
0570-20-0291 (Англи, Хятад, Солонгос, Испани, Португал)
[2015 оны 9-р сарын 30 хүртэл]
9:30-17:30 цаг хүртэл ажлын өдрүүдэд (Бямба, Ням гариг, бүх нийтийн амралтын өдөр, Үндэсний баяр наадмын өдрүүдээр ажиллахгүй)
[2015 оны 10-р сарын 1 - 2016 оны 3-р сарын 31]
9:30-20:00 ажлын өдрүүдээр, 9:30-17:30 амралтын өдрүүдээр
Жич: Navi-Dial үйлчилгээг ашиглаж байгаа учир дуудлага хийхэд төлбөртэй.



**Хувийн дугаараа
болгоомжтой
ашиглаарай. Энэ нь таны
насан туршид х
байх болно** Ү

① 10 сараас “My number” танруу илгээгдэх болно.

- ◆ Япон улс “My number” тогтолцоог хэрэгжүүлж эхлэх гэж байна.
- ◆ Энэ нь хүн тус бүрт ганц байх дугаар бөгөөд захиргааны байгууллагад хандахад хэрэглэгдэх юм.
- ◆ 2015 оны 10 сараас та бүхний гэрийн хаягаар (оршин суугаа газраа бүртгүүлсэн хаягаар) дугтуй илгээх болно.
- ◆ Дугтуйнд “My number” бүхий мэдэгдэх карт хийсэн байгаа.

Дугтуй



Мэдэгдэх карт



(うら)

- 法律で定められた者以外の者が個人番号をコピーすることは、法律で禁止されています。また記載事項を改ざんした者は、法律により罰せられます。
- この通知カードを印刷された方は、お手数ですが、下記連絡先までご連絡ください。
- この通知カードは、個人番号カードの交付を受ける場合は、市町村に返送しなければなりません。



② “My number”-г чухалчлан хадгалаарай

- ◆ Мэдэгдэх картыг хаяж гээгдүүлэх, урж тасдалгүй чухалчлан хадгалахыг хүсье.
- ◆ “My number”-г хуурамчаар ашиглахаас сэргийлж шаардлагагүй тохиолдолд бусдад өөрийн дугаарыг мэдэгдэхгүй байхыг анхаарна уу.

③ “Хувийн дугаар бүхий карт” олгоно.

- ◆ Хувийн дугаар бүхий картад таны “My number” бичигдэх бөгөөд иргэний үнэмлэхний оронд ашиглагдана.
- ◆ Хотуудаас хамаарч конбинигээс оршин суугчийн тодорхойлолт авах боломжтой болох давуу талтай.
- ◆ Хувийн дугаар бүхий картыг авахын тулд мэдэгдэх карттай хамт илгээсэн бүртгэлийн хуудсыг бөглөж буцаан илгээнэ.

Хувийн дугаар бүхий карт

Бүртгэлийн хуудас



④ Ойлгохгүй зүйл гарвал

- ◆ Доорхи homepage болон утсаар холбогдоно уу.
 Мөн оршин суугаа хотын захиргаанаас лавлаж болно.

- Homepage
<http://www.cas.go.jp/jp/seisaku/bangoseido/index.html>
- Дуудлага хүлээн авах төв
 0570-20-0291 (англи, хятад, солонгос, испани, португаль хэлээр зөвөлгөө өгнө)
【2015.09.30 хүртэл】
 Даваа ~Баасан 9:30~17:30 (бямба, ням, баярын өдрүүдээр холбогдохгүй)
【2015.10.01~2016.3.31】
 Даваа ~Баасан 9:30~20:00 бямба, ням, баярын өдрүүдэд 9:30~17:30
 (Оны сүүл, эхэнд холбогдохгүй) * Утасны дуудлага нь төлбөртэй болно.